



**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



**ШУТИС, ГХС-ийн ХХШС-ын дэргэдэх
орос хэлний “Звёздочка” клубын
2016 - 2022 онд зохион байгуулсан ажлын
тайлан**

2016 - 2017 он

ШУТИС-ийн “Орос хэлний өдрүүд”

Гадаад хэлний институтийн Европ судлалын тэнхим, Русский центр, “Звёздочка” клубээс ШУТИС-ийн “Орос хэлний өдрүүд”-ийг 2017.03.24 – өөс 04.24 –ний өдрүүдэд зохион явууллаа.

Өдрүүдийн хүрээнд оюутнуудад зориулан “Великие открытия русских учёных” фото үзэсгэлэн, “Орос орноор” баримтат кино үзвэр, орос хэлний өдөрлөг, орос хэлний олимпиад, орос дууны уралдаан зэргийг зохиосон болно.

4-р сарын 5, 6 - нд Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль мөн ШУТИС-ийн Төв байранд зохиосон өдөрлөгийн үеэр Орос улсын соёл, түүх, хэлийг сурталчилж “Орос орныг хэн сайн мэдэх вэ?” АХА тэмцээн, оросын үндэсний хоол хийх үзүүлэх сургууль хийсэн ба баримтат кино, фото-үзэсгэлэн үзүүлэв.

ШУТИС-ийн нийт оюутан залуучууын дунд 3 үе шаттайгаар зохион байгуулсан орос хэлний олимпиадад инженерийн ангиас С.Хонгорзул /ЭХС/ 1-р байр, Г.Намжинбаатар /ЭХС / 2-р байр, С.Серикбай /ЭХС/ 3-р байрыг, хэлний ангийн болон орос хэлийг гүнзгийрүүлэн судалсан оюутнуудаас 1-р байрыг Н.Саруул /ХШУС/, 2-р байрыг Ө.Болдбаатар /ХШУС/ нар тус тус эзлэв.

Харин орос дууны уралдаанд 1-р байрыг С.Серикбай /ЭХС/, 2-р байрыг Т.Ирмүүн /БАС/, 3-р байрыг З.Мөнхцацрал /ГХИ/ нар тус тус эзлэж, диплом мөнгөн шагналаар шагнагдлаа.







2017 оны 10 сарын 31-нд Орос, Англи, Хятад, Герман хэл дээр “Особо охраняемые природные территории России” постер илтгэлийн уралдаанд нийт 30 оюутан илтгэл хэлэлцүүдэв.



I байр Э.Энэрэл /ЭХС/,

II байр Н.Буянбадрах /ЭХС/,

III байр Н.Саруул, Г.Мөнхбат /ХШУС/
тус тус эзлэн өргөмжлөл, мөнгөн
шагналаар шагнуулав.



2017 – 2018 он

Орос-Монголын Найрамдалын сарын ажлын хүрээнд ШУТИС-ийн ГХИ-ийн Европ судлалын тэнхим, “Русский центр” болон “Звёздочка” клуб хамтран зохион байгуулсан “Орос орны дурсгалт хөшөө, уран барилга, түүхэн газрууд” сэдэвт уран зураг болон макетын уралдаан 2017-11-р сарын 8-нд амжилттай болж өнгөрлөө.

Уг уралдаанд нийт 32 оюутан бүтээлээ ирүүлснийг БАС-ийн Ж.Энхтүвшин, ҮТС-ийн багш Б.Сэлэнгэ, ГХИ-ийн багш Б.Банзрагч нарын бүрэлдэхүүнтэй комисс шалгаруулж шагнал гардуулав.

Тус уралдаанд **уран зургийн төрөлд** БАС-ийн оюутан / В161320073/ А.Бадамсүрэн 1-р байр, Ө. Мөнхдүүрэн / В161320110/ 1-р байр, ХШУС-ийн оюутан М. Эрдэнэ / В150900109/ 2-р байр, МТС-ийн оюутан Ц. Төгөлдөр / В170590719/ 3-р байр **макетын төрөлд** БАС-ийн оюутан С.Мөнгөнтуяа /В161320088/ 1-р байр, БАС-ийн оюутан А. Наран-Ачит /В141320093/ 2-р байр, ЭХС-ийн оюутан Б. Мягмардорж / М.ТР12D040/ 3-р байр, МТС-ийн оюутан Б.Ганбат / В171110017/, Ц.Золжаргал / В171080003/ 4-р байр, **уран барималын төрөлд** ЭХС-ийн оюутан Б.Цогтгэрэл 1-р байр тус тус эзлэв.


Уг арга хэмжээний үеэр макетуудыг нийт оюутнуудад дэлгэн сонирхуулж, Оросын эртний архитектур, хотуудын тухай видео-кино үзүүлэв.



2018 оны 3-р сарын 26-наас 4-р сарын 6-нд ШУТИС-ийн Гадаад хэлний институтын Европ судлалын тэнхим, “Русский центр” ба “Звёздочка” клубээс хариуцан зохион байгуулсан уламжлалт “Орос хэлний өдрүүд” ОХУ-ын их, дээд сургуулиудыг сурталчлах арга хэмжээгээр эхэллээ. Учир нь жил ирэх бүр тус улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцуулах оюутны тоог нэмэгдүүлж байгаа бөгөөд үүнд манай ШУТИС-ийн оюутнууд хамрагдах бололцоо илүү их байгааг энэ арга хэмжээний үеэр оюутнууд онцлон ярьж байлаа. Энэ өдрүүдийн хүрээнд оюутнуудын дунд орос хэлний олимпиадыг 3 үе шаттайгаар зохион байгуулж, орос хэлний сургалттай ЕБС төгссөн оюутнуудаас Т.Баярцэцэг /БАС/ 1-р байр, Д.Даваахүү /ЭХС/ 2-р байр, М.Буянбадрах /ГХИ/ 3-р байр, инженерийн салбарын оюутнуудаас Э.Энэрэл /БАС/ 1-р байр, Б.Мичидмаа /МХТС/ 2-р байр, Г.Удвал /МехТС/ 3-р байр эзэллээ.

Оюутны “Звёздочка” клубээс орос хэлний өдөрлөгийг зохион байгуулж, энэ үеэр Орос орон, Оросын ард түмний түүх, ёс заншил, орос хэлний талаарх өөрсдийн мэдлэгийг сорьсон АХА тэмцээн ихээхэн сонирхолтой болж өнгөрөв. Мөн “Миний дуулах дуртай орос дуу” сэдэвт дууны уралдаан болж манай авьяаслаг оюутнууд өрсөлдснөөс Б.Бат-Эрдэнэ /БАС/ тэргүүн байр, З.Батцэцэг /БАС/ 2-р байр, Б.Мажигсүрэн /ЭХС/, Б.Ганхүү /БАС/ нар удаах байрыг эзлэв.





2018 – 2019 он

Гадаад хэлний институтийн Европ судлалын тэнхим ба “Звёздочка” клубээс Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд орос хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ШУТИС-ийн оюутнуудын дунд “FIFA” 2018 в России” сэдэвт хөшөө дурсгал, уран барилгын макетын уралдаан, “Твори добро!” сэдэвт оюутны постер илтгэлийн тэмцээнийг зохион байгуулсан.

1. 2018-10-р сарын 19-нд “FIFA” 2018 в России” сэдэвт Оросын алдартай хөшөө дурсгал, уран барилгын макетын уралдаан амжилттай болж өндөрлөлөө.

15 оюутаны бүтээлээс:

1-р байр МТС-ийн оюутан А.Энхтүвшин,
2-р байр ГХИ-ийн оюутан У.Энхбаяр,
Б.Дүүрэнбилэг, М.Дөлгөөн нар,
3-р байр БАС-ийн оюутан Э.Дэмбэрэлцэрэн,
4-р байр ГХИ-ийн оюутан Ц.Цэнгэнбал,
Б.Ганболд, Э.Цогжавхлан нар тус тус эзлэв.



2. Орос улс 2018 оныг “Сайн дурынханы жил” болгон зарласан юм. Оюутан залуучуудын нийгмийн идэвх оролцоог дээшлүүлэх, бусдын сайн сайхны төлөө өөрийн хүч чадал, амьдралын нэгээхэн хэсгийг хариу нэхэлгүй, чин сэтгэлээсээ зориулах хүсэл эрмэлзэлийг төрүүлэх зорилгоор “Твори добро” сэдэвт постер илтгэлийн тэмцээн 2018оны 10 сарын 26-ны өдөр ШУТИС-ийн “Русский центр” төвд амжилттай зохион байгуулагдлаа.



22 оюутан Орос, Англи, Хятад, Герман хэл дээр илтгэл тавьсанаас:
 1-р байранд Н.Саруул /МХТС/,
 2-р байранд Н.Гангэрэл, Б.Ганжавхлан /ГХИ/,
 3-р байранд Б.Саруул, А. Тэргэл / БАС /,
 тусгай байрт Б. Даваахүү /ЭХС/ нар шалгарав.

2.世界10大人气最高的旅游国家

International Red Cross and Red Crescent Movement and Russian Red Cross Society

3. Клубын гишүүд ололт амжилтуудаа нэгдсэн хурлаар хэлэлцэв.



4. 2019 оны 5 сарын 9-нд Аугаа их эх орны дайны ялалтын 74 жил, Халх голын ялалтын 80 жийлийн ойн хүрээнд “Үхэшгүй мөнхий хороо” хүндэтгэлийн жагсаалд ШУТИС-ийг төлөөлөн ГХС-ийн “Звёздочка” клубийн гишүүд болон орос хэл судлаж буй оюутнууд нийт 32 оюутан оролцов.







“Звёздочка”
клубын нээлтийн
үйл ажиллагаа
амжилттай болж
өндөрлөлөө.




С.Маршакийн
“Кошкин Дом”
үлгэрээр жүжигчилсэн
тоглолт ХХШС-ын
багш нарт толилуулав.
2019.09.28-нд



*Клубын “Чамд би туслах уу?” англи хэлний хичээл орж хэл сурах арга барилаасаа хуваалцав.
2019.11.15-нд*



Клубын гишүүд РЦНК-д “Крымский мост” орос уран сайхны кино үзсэв. 2019.10.25-нд





Орос Монголын найрамдлын сар болон “80-летие исторических событий на Халхин-Голе”-ын хүрээнд хүрээнд клубын гишүүд Монгол цэргийн музей үзэж сонирхов.



“40-летие Московской олимпиады-80” сэдэвт оюутны постер илтгэлийн уралдаанд нийт 27 баг оролцож, орос, англи, герман, хятад, япон, солонгос хэлээр илтгэл тавив.





*Шинжлэх ухаан,
техник
технологийн орос
хэлний "АХА"
тэмцээн зохион
байгуулж шагнал
гардуулав.*



Клуб суртачилах өдөрлөгт амжилттай оролцов.





*ШУТИС БАС-аас
зохион
байгуулсан Англи
хэлний "Golden
bell" тэмцээнд
Звёздочка клубын
гишүүн Хүслэн 1-р
байр
Намуун 2-р байр
тус тус эзэлсэн.*

*ШУТИС-ын Англи
хэлний аварга A-
team. Best speaker
англи хэлний
ярианы ур
чадварын
тэмцээнд Клубын
гишүүд 1-р байр.
2019.11.12-нд*





НУБ-аас 2020 оныг ургамлын эрүүл мэндийг хамгаалах жил болгон зарласантай холбогдуулан оюутан залуусыг байгаль, эх дэлхийгээ хамгаалах үйлст уриалах, ногоон ургамлыг хамгаалахын ач холбогдлыг таниулах зорилгоор “Здоровье растений - наше здоровье” сэдэвт постер илтгэлийн уралдааныг арга хэмжээний хүрээнд зохион байгууллаа.




“Читаем Пушкина на разных языках” шүлгийн уралдаан 2020.10.22-ны өдөр “Русский центр” амжилттай зохион байгуулав.

“Оросын эртний архитектур ба дурсгалт хөшөө” сэдэвт макетын уралдаан 2020.11.06-ны өдөр “Русский центр”-т амжилттай зохион байгуулагдаж өнгөрлөө.





2020-2021 он



ШУТИС, ГХС-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын харьяа “Звёздочка” клубийн 10 жилийн ойн баярын хүрээнд зохион байгуулагдаж буй “Гадаад хэл сурах нь амьдралыг харах өнцгийг өөрчилдөг” цуврал лекцийн эхний дугаар 4 дүгээр сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Уг лекц нь Google meet болон Facebook

шууд дамжуулалтаар улс орон даяар цацагдсан бөгөөд давхардсан тоогоор 150 гаруй суралцагч, оюутан залуус болон багш ажилчид хамрагдсан билээ.

Facebook лайв үзэх: <https://www.facebook.com/watch/?v=754542625259509> Дэлгэрэнгүй мэдээлэл: <http://fli.edu.mn/mn/page/722>



“Гадаад хэл сурах нь амьдралыг харах өнцгийг өөрчилдөг” цуврал лекцийн хоёрдугаар дугаар амжилттай зохион байгуулагдлаа.




Гадаад хэлний мэдлэг олгох үүрэгтэй Звёздочка клубийн гишүүд ярилцан “Эх хэлний мэдлэг гадаад хэл сурахын үндэс” сэдэвтэйгээр зохион байгууллаа.

Зочин илтгэгчээр:

1. ШУТИС, ГХС-ийн АСТ-ийн ахлах багш доктор (PhD) Ч. Оюунгэрэл
2. БНСУ-ын Dankook их сургуулиас ШУТИС-т монгол хэл суралцсан 2019 оны солилцооны оюутан Ким ЖэВон
3. ШУТИС, ГХС-ийн 3-р курсийн оюутан С. Пүрэв-Эрдэнэ

Уг лекц маань Google Meet ашиглан зохион байгуулагдсан бөгөөд мөн фэйсбүүк хуудаст Шууд дамжуулалт хэлбэрээр явагдлаа. Нийт оролцогчидын тоо 80-100 хооронд хэлбэлзсэн ба оролцсон бүхий л оюутан, суралцагч, багш ажилчидад эх хэлний мэдлэг ач тусын талаар арвин их мэдлэгийг олгож чадлаа.



“

Speaker #1

Хэл шинжлэлийн ухааны доктор(Ph.D) Ч. Оюунгэрэл

-ШУТИС, ГХС-ийн АСТ-ийн ахлах багш

“Өөрөө өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох хэрэггүй!”

<https://www.facebook.com/ayungerel.ayungerel.12532>

“

Speaker #2

Ким ЖэВон

-БНСУ-ын Dankook их сургуулиас ШУТИС-ийн 2019 оны солилцооны оюутан

“WHEN YOU FOCUS ON THE GOOD, THE GOOD GETS BETTER!”

[erlifefm_j](https://www.instagram.com/erlifefm_j)

“

Speaker #3


ШУТИС, ГХС-ийн 3-р курсийн оюутан С. Пүрэв-Эрдэнэ

-Техник технологийн орчуулгын Орос, Англи хэлний анги

“FACE EVERYTHING WITH A POSITIVE MIND”

<https://www.facebook.com/puuje07>



[epuuje07](https://www.instagram.com/epuuje07)




Клубийн хэлний хичээлийн үйл ажиллагаа

Англи хэл долоо хоног бүрийн 2 дах өдөр 18:00 цагт клубийн TEAMS-ээр хичээллэж багшаар клубийн тэргүүн М. Самбууням

Орос хэл долоо хоног бүрийн 3 дах өдөр 18:00 цагт клубийн TEAMS-ээр хичээллэж багшаар клубийн гишүүн С. Пүрэв-Эрдэнэ




Цар тахал хөл хорионы улмаас Звёздочка клубээс зохион байгуулдаг “Миний дуулах дуртай орос дуу” сэдэвт дууныг 8 хэл дээр онлайн хэлбэрээр зохион байгууллаа.




2021-2022 он



2022 оны 4 сарын 8-нд клубээс зохион байгуулдаг орос хэлний хичээл дээрээ Оросын уламжлалт баяр болох Масленицаг клубын хүрээндээ тэмдэглэсэн бөгөөд Масленицагийн талаар сонирхолтой мэдээллийг авсан.





2022 оны 4 сарын 15-нд Гадаадад сурдаг монгол оюутнуудтай ярилцлага хийсэн.




Зочин илтгэгчид болох С.Кирилл ИГМУ (Иркутск Государственный Медицинский Университет) У.Уянгаа Канад улсын Манитабо их сургууль) нар гадаадад хэрхэн амжилттай суралцах талаар өөрсдийн туршлага, мэдлэгээ хуваалцан мөн оюутнуудын асуултанд хариулан чөлөөтэй ярилцсан.



Звёздочка клубээс "Ерөнхийлөгчийн илгээлт-2100" хөтөлбөрийн орос хэлний оюутнуудыг ОХУ-д Эрхүүгийн Үндэсний судалгааны технологийн их сургуулийн (Иркутский национальный исследовательский технический университет) Хүнсний технологич мэргэжлээр төгссөн Б. Энхзаяа болон УрФУ-ийн магистрантурт эрчим хүний дулааны мэргэжилээр төгссөн Э.Бат-Оргилтой хэлний бэрхшээлийг хэрхэн даван туулах, орчинтойгоо дасан зохицох, биеэ зөв авч явах, гадаад сурахын давуу тал, ажлын байр олоход хэрхэн нөлөөлсөн талаар туршлагаас нь хуваалцаж онлайн ярилцлага хийсэн.





Англи хэлний хичээлийг клубын хүндэт гишүүн-багш М.Самбууням удирдан явуулсан бөгөөд хичээлийг “Barron’s essential words for IELTS” номноос орсон.



Хэн сайн үг цээжлэх вэ? сэдэвт С2 түвшиний 100 үг цээжлэх АХА /англи хэл/ бооцот тэмцээн амжилттай зохион байгуулав



Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх үүднээс “Хамрын хийд”-рүү галт тэргээр нэг өдрийн аялал хийв.



Ковидын дараа зөвхөн монголчуудын гэлтгүй дэлхий нийтэд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд гаарсан бөгөөд хямралын үед хүүхэд, залуучуудын нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдлыг хангах тулд “Урам зориг түгээе” аяныг зохион байгуулав.



11,411
Хүрсэн хүний тоо

874
Engagements

Нийтлэлийг дэмжих

41,661
Хүрсэн хүний тоо

3,296
Engagements

Нийтлэлийг дэмжих



5 сарын 8-нд болсон Ялалтын баярт зориулсан “Бессмертный Полк” буюу “Үхэшгүй мөнхийн хороо” гэх Халх гол, Эх орны дайнд амь үрэгдсэн дайчид, ард иргэдийг хүндэтгэх жагсаалд оролцсон. Монгол улсад байнгын оршин суудаг, ажилладаг, орос иргэдтэй ярианы дадлага хийсэн ба ОХУ-ын элчин сайдын ажилчид бид бүхэнд талархал илэрхийлэв.



Эрүүл мэнд эрхэм баян гэх сэдвийн хүрээнд “Би зөв” аяныг зохион байгуулав.



